Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 709,455.6 мянган төгрөг болж 166,124.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 16,258.3 мянга, өөрийн хөрөнгөөр 5,825.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 2/64 дүгээр тушаалаар Өвгөн жаргалант зуслангийн халуун усны барилгыг 81,730.1 мянган төгрөгөөр, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын дагуу 13,311.0 мянган төгрөгийн хашааг барилга байгууламж дансанд бүртгэсэн, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай" 107 дугаар захирамжаар 17,590.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 31,410.0 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн цалингаас суутгасан ХХОАТ-ын 1,562.1 мянга, газрын төлбөрийн 96.1 мянган төгрөг нийт 1,658.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 139,143.2 мянган төгрөгөөр өсөж 562,557.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 971,351.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 971,351.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 3 удаа тодотгол хийж 101,403.5 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 869,947.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 869,947.7 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

гүйцэтгэлээр улсын төсвөөс 857,695.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 12,251.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 857,695.8 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,251.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Улсын төсөв** | | | | |
| 1 | 70227 Хүүхдийн хөгжил хамгаалал | 847,710.7 | 835,672.4 | 12,038.3 | 98.6 |
| 1.1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 448,210.9 | 436,495.9 | 11,715.0 | 97.4 |
| 1.2 | 80236 Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал | 3,529.2 | 3,523.5 | 5.7 | 99.8 |
| 1.3 | 80237 Хамгаалал нөхөн сэргээх үйлчилгээний бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал | 344,170.6 | 343,905.8 | 264.8 | 99.9 |
| 1.4 | 80238 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал | 50,300.0 | 50,247.2 | 52.8 | 99.9 |
| 1.5 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 1,500.0 | 1,500.0 | 0.0 | 100.0 |
| 2 | 72209 Залуучууд болон оюутнуудын бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал | 14,237.2 | 14,031.0 | 206.2 | 98.6 |
| 2.1 | 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааны зардал | 14,237.2 | 14,031.0 | 206.2 | 98.6 |
| 3 | 72212 гэр бүлийн хөгжил хамгаалал | 7,999.8 | 7,992.4 | 7.4 | 99.9 |
| 3.1 | 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааны зардал | 7,999.8 | 7,992.4 | 7.4 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна. (мянган төгрөг)

| № | Санхүүжилт олгосон байгууллага | Орлогын төрөл | Санхүүжилтийн дүн |
|---|---|---|---|
| 1 | НҮБ-ын Хүүхдийн сан | Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн авах зардал | 25,000.0 |
| 2 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | "Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал" сургалтын зардал | 3,400.0 |
| 3 | Удирдлагын академи | "2050 нэкст жейн" төслийн санхүүжилт | 19,869.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Гэр бүлийг дэмжих төслийн санхүүжилт | 25,405.0 |
| 5 | Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт | | 63,169.0 |
| 6 | | Зуслангийн орлого | 128,285.0 |
| 7 | | Хуримын ордны орлого | 57,491.9 |
| | **Нийт дүн** | - | **322,619.9** |

Дээрх хөрөнгүүдийг зориулалтын дагуу зарцуулж үрийн мөнгөний орлого 80.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 41,428.3 мянга, гэрэл цахилгааны зардалд 4,298.6 мянга, цэвэр, бохир усны зардалд 3,701.5 мянга, шатахууны зардалд 786.2 мянган төгрөг батлагдаж “РМВ” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Чандмань-Баянхонгор" ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээ, "Петровис" ХХК-тай шатахууны гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 1/500 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсөв 869.947.7 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 869.947.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.049.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9.134.65 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 165.4 мянга буюу 3.8 хувь, халаалтын зардлыг 1,504.8 мянга буюу 2.5 хувь, цэвэр бохир усны зардлыг 2,305.8 мянга буюу 62.3 хувиар хэмнэсэн бөгөөд нийт 3,976.0 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Мөн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” А/11 дүгээр тушаалаар гэр бүл, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил оролцооны чиглэлээр албан байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулахдаа хоолны зардалд 270.0 мянган төгрөгийг зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 154 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 37 гэрээ байршуулахаас 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 147 тушаал байршуулахаас 1 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 386,424.2 мянган төгрөгийн 45 гүйлгээ мэдээлэхээс 59,756.5 мянган төгрөгийн 8 гүйлгээг мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 23,159.3 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 5,580.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч, 13,311.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага тогтоож, 4,268.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосныг биелүүлж ажиллан биелэлтийг Баянхонгор аймгийн ГБХЗХГ-ын даргын 2023 оны 06 дугаар 22-ны 363, 2023 оны 09 дүгээр 06-ны өдрийн 403 дугаар албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 3 | 4,268.3 | 3 | 4,268.3 | 100 |
| Албан шаардлага | 2 | 13,311.0 | 2 | 13,311.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 5,580.0 | 1 | 5,580.0 | 100 |
| **Нийт дүн** | **6** | 23,159.3 | **6** | 23,159.3 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хуримын ордны барилгыг улсын комисс хүлээн аваагүй, 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр улсын комисс ажилласан боловч нэмэлтээр ажил гүйцэтгэх үүрэг өгч ажлыг хийсэн, одоогоор улсын комисс хуралдаагүй байгаа тул дараагийн аудитаар нэмэлтээр хийгдсэн ажил болон бүртгэл тайланд тусгасан эсэхийг шалгах.

Санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд иргэнээс өргөдөл ирсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 97 дугаар албан бичгээр ХЧТАТ-ийг нягтлан бодогч Л.Батнасан 2024 оны 05 дугаар сард багтаан төлөхөөр ирүүлсэн бөгөөд дээрх мөнгийг өгсөн эсэхийг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 183,331.8 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Цалингийн урьдчилгааны 50,570.0 мянга, 7-12 дугаар сарын цалингийн 132,761.8 мянган төгрөгийг байгууллагад төлөх өглөгийн дансаар бүртгэсэн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитаар нийт 51,337.7 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрснээс, 1,638.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 48,041.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,658.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 3,296.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,838.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1. Даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” А/11 дүгээр тушаалаар гэр бүл, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил оролцооны чиглэлээр албан байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулахдаа хоолны зардалд 270.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар хоолны зардалд зарцуулсан 250.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. “Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал” сургалтыг Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдад 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд мэргэжилтэн нарт тус бүр 1 өдрийн томилолтын зардал 64.0 мянга, нийт 128.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардалд илүү олгосон 128.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3. “Ашид мөнх тод” ХХК-д бараа материалын үнэнд 250.0 мянга, “Баялаг тайхар” ХХК-д 960.0 мянга нийт 1,240.0 мянган төгрөгийг бараа материалын зардалд илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын зардалд илүү шилжүүлсэн 1,240.0 мянган төгрөгийг нягтлан бодогчоор төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**5.2 Албан шаардлага**

5.2.1. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 37 гэрээ байршуулахаас 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 147 тушаал байршуулахаас 1 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 374,709.2 мянган төгрөгийн 44 гүйлгээ мэдээлэхээс 48,041.5 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u> Тайлант хугацаанд Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн цалингаас суутгасан ХХОАТ-ын 1,562.1 мянга, газрын төлбөрийн 96.1 мянган төгрөг нийт 1,658.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Өр төлбөрийг хууль, журмын хүрээнд барагдуулж, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч, цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 183,331.8 | - | - | 1 | 183,331.8 | 1 | 183,331.8 | - | - |
| Дүн | **1** | **183,331.8** | **-** | **-** | **1** | **183,331.8** | **1** | **183,331.8** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” А/11 дүгээр тушаалаар гэр бүл, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил оролцооны чиглэлээр албан байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулахдаа хоолны зардалд 270.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 270.0 | 1 | 270.0 | - | - | - | - |
| Томилолтын зардлыг тулган шалгахад 2 албан хаагчид нийт 128.0 мянган төгрөгийг томилолтын зардалд илүү олгосон байна. | 1 | 128.0 | 1 | 128.0 | - | - | - | - |
| “Ашид мөнх тод” ХХК-д бараа материалын үнэнд 280.0 мянга, “Баялаг тайхар” ХХК-д 960.0 мянга нийт 1,240.0 мянган төгрөгийг бараа материалын зардалд илүү шилжүүлсэн байна. | 1 | 1,240.0 | 1 | 1,240.0 | - | - | - | - |
| Тайлант хугацаанд Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн цалингаас суутгасан ХХОАТ-ын 1,562.1 мянга, газрын төлбөрийн 96.1 мянган төгрөг нийт 1,658.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. | 1 | 1,658.2 | - | - | - | - | 1 | 1,658.2 |
| Дүн | **4** | **3,296.2** | **4** | **1,638.0** | **-** | **-** | **1** | **1,658.2** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 37 гэрээ байршуулахаас 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 147 тушаал байршуулахаас 1 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 374,709.2 мянган төгрөгийн 44 гүйлгээ мэдээлэхээс 48,041.5 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 48,041.5 | - | - | 1 | 48,041.5 | - | - |
| Дүн | **1** | **48,041.5** | **-** | **-** | **1** | **48,041.5** | **-** | **-** |

-----------оОо----------



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 19 өдөр    Дугаар 16/А0571121 БНА-2024/08/НА-СТА-ТШЗ    Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын зардлыг тулган шалгахад 2 албан хаагчид тус бүр 64,000 төгрөг, нийт 128,000 төгрөгийг томилолтын зардалд илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэсэн заалыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050052

1. Томилолтын зардалд илүү олгосон 128,000 (нэг зуун хорин найман мянга) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, нягтлан бодогч Л.Батнасан нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6477143544
РЮ 00067 0007423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 07/А0571121 ВНА-2024/08/НА-СТА-ТЦЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” А/11 дүгээр тушаалаар гэр бүл, хүүхэд, залуучуудын эрх, хөгжил оролцооны чиглэлээр албан байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулахдаа хоолны зардалд 270,000 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 270,000 (хоёр зуун далан мянга) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5050055

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, нягтлан бодогч Л.Батнасан нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417743544
5-2000287 9007423

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 18/А0571/21 БНА-2024/08/АНА-СТА-Т443 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Ашид мөнх тод" ХХК-д бараа материалын үнэнд 250,000 төгрөг, "Баялаг тайхар" ХХК-д 960,000 төгрөг нийт 1,240,000 төгрөгийг бараа материалын зардалд илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бараа материалын зардалд илүү шилжүүлсэн 1,240,000 (нэг сая хоёр зуун дөчин мянга) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5050056

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, нягтлан бодогч Л.Батнасан нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417143544
БНДАО067 9007423

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 25/А0571121 БНА-2024/08/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 37 гэрээ байршуулахаас 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 147 тушаал байршуулахаас 1 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 374,709,200 төгрөгийн 44 гүйлгээ мэдээлэхээс 48,041,500 төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040079

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасны дагуу 7 гэрээ, 1 тушаал, зарлагын 48,041,500 төгрөгийн 7 гүйлгээг бүрэн байршуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Н.Мэндбаяр, нягтлан бодогч Л.Батнасан нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно